

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2018 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1.	Аудитын гэрчилгээ.....	2
2.	Аудитын тайлан	4
2.1	Оршил.....	4
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	6
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	7
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.8.1.	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал ..	8
2.9.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал ...	8
2.10.	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
2.11.	Шилэн дансны мэдээлэл	8
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	8
2.13.	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	9
3.	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	10
3.1	Аудит хийсэн санхүүгийн тайлан	10
3.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	11
3.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	12
3.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлтийн тайлан	13
3.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	14

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
БХБЯ	Барилга, хот байгуулалтын яам
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ЗТБХБЯ	Зам тээвэр барилга, хот байгуулалтын яам
ТХН	Төсөл хөтөлбөрийн нэгж
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН
ЯАМНЫ ИНЖЕНЕРИЙН ДЭД БҮТЦИЙН
БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ
ЗОХИЦУУЛАХ ГАЗРЫН ДАРГА
Т.БОЛОРЧУЛУУН ТАНАА

2019.02.25 № 06/288
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8.9.1 дугаар зүйлд заасны дагуу Замын-Үүдийн дэд бүтцийг сайжруулах төслийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Замын-Үүдийн дэд бүтцийг сайжруулах төслийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Замын-Үүдийн дэд бүтцийг сайжруулах төслийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Аудитын гол асуудал

“Замын-Үүдийн дэд бүтцийг сайжруулах төсөл”-ийн нэгжийн үйл ажиллагаа 2018 онд дууссан боловч, тус төслийн нэгжийн Төрийн сан дахь 100900029014 тоот харилцах дансны 44.3 сая төгрөгийн үлдэгдлийг улсын төсөвт төвлөрүүлээгүй байна. Энэ нь санхүүгийн тайлангийн Үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1 Оршил

Замын-Үүдийн дэд бүтцийг сайжруулах төслийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Инженерийн дэд бүтцийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Т.Болорчулуун Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Замын-Үүдийн дэд бүтцийг сайжруулах төслийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Замын-Үүдийн дэд бүтцийг сайжруулах төслийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 01 дүгээр сарын 25-наас 02 дугаар сарын 22-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 02 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын аудитор Б.Энхжин хариуцаж хэрэгжүүлэв.

Замын-Үүдийн дэд бүтцийг сайжруулах төслийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2019 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 207 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Замын-Үүдийн дэд бүтцийг сайжруулах төслийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Замын-Үүдийн дэд бүтцийг сайжруулах төсөл нь Монгол Улсад БНХАУ-ын Засгийн газрын 300.0 сая ам долларын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжих 5 төслийн нэг юм. Энэхүү төсөл нь Замын-Үүдийн дэд бүтцийг шинэчлэн сайжруулах, Замын-Үүд эдийн засгийн чөлөөт бүсийн 3,4-р хэсгийн дэд бүтцийг шинээр барьж байгуулах зорилготой хэрэгжсэн байна.

Үйл ажиллагааны чиглэл:

Замын-Үүдийн дэд бүтцийг сайжруулах төсөл нь ЗТБХБЯ (хуучнаар) болон БНХАУ-ын төрийн өмчит “Чайна КАМК инженеринг” компаний хооронд 2010 оны 05-р сарын 09-ний өдөр байгуулсан гэрээний дагуу 4 багц ажлыг хийж гүйцэтгэхээр төлөвлөсөн байна. Төслийн барилга угсралтын ажил 2012 оны 4-р сараас эхэлсэн ба дулаан хангамж, ус хангамж, ариутгах татуурга, цахилгаан хангамж авто зам, холбоо дохиолол гэсэн 4 багцын барилга угсралтын ажлыг гүйцэтгэж дууссан байна.

Замын-Үүдийн дэд бүтцийг сайжруулах төслийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Замын-Үүдийн дэд бүтцийг сайжруулах төслийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн

байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль

Байгууллага, түүний орчны талаарх мэдээллийг судлах явцад тайлант хугацаанд гарсан онцлог өөрчлөлт, анхаарах асуудлыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

- Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн хуралдаанаар Дорноговь аймгийн Замын-Үүд сум болон Замын-Үүдын чөлөөт бүсийн нутаг дэвсгэрт байрлах ус, дулаан, цахилгаан хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах зорилгоор ашиглалтын өмнөх захиргаа байгуулах тухай асуудлыг хэлэлцээд Засгийн газрын гишүүдээс гаргасан саналын дагуу эрхлэх асуудлын хүрээнд шийдвэрлэх нь зүйтэй гэсэн шийдвэрийг гаргасан байна.
- МУЗГ-ын шийдвэрийн дагуу Барилга, хот байгуулалтын сайдын 2018 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн 27 дугаар тушаалаар Ашиглалтын өмнөх захиргаа байгуулсан байна.
- БХБЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2018 оны Б/32 дугаар тушаалаар ТХН-д ажиллаж байсан албан хаагчдыг ажлаас чөлөөлсөн байна.
- ТӨБЗГ-ын 2018 оны 435 дугаар тогтоолоор ТХН-ийн балансад бүртгэлтэй 123,998.0 сая төгрөгийн хөрөнгийн ашиглалтын өмнөх захиргаанд балансаас балансад шилжүүлж, 436 дугаар тогтоолоор 20.0 сая төгрөгийн балансын үнэ бүхий автомашиныг дуудлага худалдаагаар худалдсан байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Замын-Үүдийн дэд бүтцийг сайжруулах төсөл санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Замын-Үүдийн дэд бүтцийг сайжруулах төсөл санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Magic finance” програм хангамж ашигладаг байна.

Замын-Үүдийн дэд бүтцийг сайжруулах төслийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт сул байна гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Замын-Үүдийн дэд бүтцийг сайжруулах төслийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 4 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 4 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Нийт хөрөнгийн 0.2 хувиар сонгов.

Нийт хөрөнгийг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын суурийг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэнтэй холбоотой.

Замын-Үүдийн дэд бүтцийг сайжруулах төслийн 2018 оны нийт хөрөнгө 44,351.7 мянган төгрөг бөгөөд түүний 0.2 хувь болох 88.7 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг төлөвлөлтийн шатанд тогтоосон 0.2 хувийг өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 4 чиглэлээр аудитын 7 горим сорил гүйцэтгэж, 4 асуудлыг аудитын явцад залрууллаа.

Аудитын явцад санхүүгийн тайланд нийт 292,407.2 мянган төгрөгийн алдаа зөрчлийг залруулсан болно. Үүнд:

- 40.7 мянган төгрөгийн бараа материалын зардлыг үр дүнгийн тайланд тусгаагүй,

- Тайлант үеийн үр дүнг 123,997.6 мянган төгрөгөөр буруу илэрхийлсэн,
- Өмнөх үеийн үр дүнг 124,017.2 мянган төгрөгөөр буруу илэрхийлсэн зэрэг зөрчлийг аудитын явцад залруулсан болно.
- “Замын-Үүдийн дэд бүтцийг сайжруулах төсөл”-ийн нэгжийн Төрийн сан дахь 100900029014 тоот харилцах дансны 44,351.7 мянган төгрөгийн үлдэгдлийг аудитын явцад улсын төсөвт төвлөрүүлэв.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас шийдсэн алдаа, зөрчилтэй асуудал байхгүй болно.

2.9. ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Замын-Үүдийн дэд бүтцийг сайжруулах төслийн нэгжийн үйл ажиллагаа 2018 онд дууссан тул дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудал байхгүй болно.

2.10. ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Замын-Үүдийн дэд бүтцийг сайжруулах төслийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 1 хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 8,974,00.0 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас зардлын нийт гүйцэтгэл 8,521,436.5 мянган төгрөг буюу 95.0 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 3.5-д дэлгэрэнгүй харуулав.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Замын-Үүдийн дэд бүтцийг сайжруулах төсөл нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус төсөл хөтөлбөрийн нэгж нь татан буугдаж байгаатай холбоотойгоор www.Shilendans.gov.mn цахим хуудсанд татан буугдсан байгууллагын жагсаалтад орсон байна.

2.12. ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Замын-Үүдийн дэд бүтцийг сайжруулах төслийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Замын-Үүдийн дэд бүтцийг сайжруулах төслийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Аудит хийсэн санхүүгийн тайлан

3.1 Аудит хийсэн САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан /төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>19,601,790.77</u>	<u>44,351,713.97</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	19,561,090.77	44,351,713.97
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	19,561,090.77	44,351,713.97
3121	Төгрөг	19,561,090.77	44,351,713.97
Ы31211	Төрийн сангийн харилцах	19,561,090.77	44,351,713.97
35	БАРАА МАТЕРИАЛ	40,700.00	0.00
354	Хангамжийн материал	40,700.00	0.00
35420	Аж ахуйн материал	40,700.00	
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>123,997,591,919.45</u>	<u>0.00</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	123,997,591,919.45	0.00
392	Биет хөрөнгө	123,997,591,919.45	0.00
39203	Авто-тээврийн хэрэгсэл	20,000,000.00	
39204	Хуримтлагдсан элэгдэл	12,666,666.00	
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	6,443,364.44	
39206	Хуримтлагдсан элэгдэл	6,443,364.44	
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	3,172,300.00	
39208	Хуримтлагдсан элэгдэл	2,986,782.00	
39216	Дуусаагүй барилга, байгууламж	123,990,073,067.45	
39301	Програм хангамж	250,000.00	
39302	Хуримтлагдсан элэгдэл	250,000.00	
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>124,017,193,710.22</u>	<u>44,351,713.97</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>124,017,193,710.22</u>	<u>44,351,713.97</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	124,017,193,710.22	44,351,713.97
512	Хуримтлагдсан үр дүн	124,017,193,710.22	44,351,713.97
51210	Өмнөх үеийн үр дүн	126,904,098,370.28	124,017,193,710.22
51220	Тайлант үеийн үр дүн	-2,886,904,660.06	-123,972,841,996.25
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>124,017,193,710.22</u>	<u>44,351,713.97</u>

3.2 Аудит хийсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	328,049,500.00	8,546,227,191.69
11	ТАТВАРЫН ОРЛОГО	-	-
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	8,546,227,191.69
120	Нийтлэг татварын бус орлого	-	8,546,227,191.69
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	8,521,436,568.49
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих		8,521,436,568.49
120009	Бусад орлого		24,790,623.20
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	328,049,500.00	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	328,049,500.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	328,049,500.00	
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	310,805,639.23	8,521,477,268.49
21	УРСГАЛ ЗАРДАЛ	310,805,639.23	8,521,477,268.49
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	310,805,639.23	40,700.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	158,997,428.83	-
210101	Үндсэн цалин	158,997,428.83	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	17,832,000.00	-
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8,581,200.00	-
210304	Байрны түрээс	8,581,200.00	
2104	Хангамж, бараа материалын зардал	1,177,000.00	40,700.00
210401	Бичиг хэрэг	997,000.00	
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	180,000.00	
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал		40,700.00
2107	Томилолт, зочны зардал	11,913,000.00	-
210702	Дотоод албан томилолт	11,913,000.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	30,864,800.00	-
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	30,864,800.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	81,440,210.40	-
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	79,122,980.40	
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	2,317,230.00	
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	8,521,436,568.49
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	8,521,436,568.49
213304	Хөрөнгийн		8,521,436,568.49
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	17,243,860.77	24,749,923.20
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	2,904,148,520.83	123,997,591,919.45
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз		7,518,852.00
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	2,904,148,520.83	
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал		123,990,073,067.45
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)	(2,904,148,520.83)	(123,997,591,919.45)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(2,886,904,660.06)	(123,972,841,996.25)

3.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан /Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>328,049,500.00</u>	<u>8,546,227,191.69</u>
11	ТАТВАРЫН ОРЛОГО	-	-
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	8,546,227,191.69
120	Нийтлэг татварын бус орлого	-	8,546,227,191.69
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	8,521,436,568.49
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих		8,521,436,568.49
120009	Бусад орлого		24,790,623.20
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	328,049,500.00	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	328,049,500.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	328,049,500.00	
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>308,488,409.23</u>	<u>8,521,436,568.49</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	308,488,409.23	8,521,436,568.49
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	308,488,409.23	-
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	158,997,428.83	-
210101	Үндсэн цалин	158,997,428.83	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	17,832,000.00	-
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8,581,200.00	-
210304	Байрны түрээс	8,581,200.00	
2104	Хангамж, бараа материалын зардал	1,177,000.00	-
210401	Бичиг хэрэг	997,000.00	
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	180,000.00	
2107	Томилолт, зочны зардал	11,913,000.00	-
210702	Дотоод албан томилолт	11,913,000.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	30,864,800.00	-
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	30,864,800.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	79,122,980.40	-
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	79,122,980.40	
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	8,521,436,568.49
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	8,521,436,568.49
213304	Хөрөнгийн		8,521,436,568.49
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>19,561,090.77</u>	<u>24,790,623.20</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	19,561,090.77	24,790,623.20
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		19,561,090.77
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	19,561,090.77	44,351,713.97

3.4 Аудит хийсэн ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан /төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл			126,904,098,370.28	126,904,098,370.28
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	126,904,098,370.28	126,904,098,370.28
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
C07	Тайлант үеийн үр дүн			-2,886,904,660.06	-2,886,904,660.06
C08	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	124,017,193,710.22	124,017,193,710.22
D01	2018 оны 1-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	124,017,193,710.22	124,017,193,710.22
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	124,017,193,710.22	124,017,193,710.22
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				0.00
D08	Тайлант үеийн үр дүн			-123,972,841,996.25	-123,972,841,996.25
D09	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	44,351,713.97	44,351,713.97

3.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	8,974,000,000.00	8,521,436,568.48	452,563,431.52	95.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	8,974,000,000.00	8,521,436,568.48	452,563,431.52	95.0
2200	Дотоод эх үүсвэрээр	8,974,000,000.00	8,521,436,568.48	452,563,431.52	95.0
222001	Тоног төхөөрөмж	8,974,000,000.00	8,521,436,568.48	452,563,431.52	95.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	8,974,000,000.00	8,521,436,568.48	452,563,431.52	95.0
14	БУСАД ЭХ ҮҮСВЭР	8,974,000,000.00	8,521,436,568.48	452,563,431.52	95.0
145005	Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх	8,974,000,000.00	8,521,436,568.48	452,563,431.52	95.0

[illegible]